



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/219-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn Сүхбаатар сум 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Б.Ундаръяа Утас: 70376994 Цахим хаяг: unddariya11@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	15
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Албан шаардлага.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОУБ	Олон улсын байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЖАВХЛАНТ СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ОЮУНЧИМЭГ ТАНАА

2024.02.23 № СМ-2024/219/НА-СМ-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жавхланта сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 7,658.4 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт,

018020273

санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/төгрөгөөр/
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,117,301.36	114,840,218.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,559,720.36	93,363,868.60
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	6,559,720.36	93,363,868.60
31210	Төгрөг	6,559,720.36	93,363,868.60
31211	Төрийн сангийн харилцах	6,524,720.36	93,328,868.60
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	35,000.00	35,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,557,581.00	21,476,350.00
35400	Хангамжийн материал	15,557,581.00	21,476,350.00
35410	Бичиг хэргийн материал	59,500.00	59,500.00
35420	Аж ахуйн материал	2,922,200.00	6,685,200.00
35460	Хүнсний материал	961,121.00	3,116,890.00
35470	Бусад хангамжийн материал	11,614,760.00	11,614,760.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	395,459,525.69	368,323,579.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	395,459,525.69	368,323,579.07
39200	Биет хөрөнгө	393,744,734.12	366,921,287.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	360,116,400.00	360,116,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(37,733,968.20)	(47,059,126.92)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	51,762,412.60	51,762,412.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,075,042.81)	(42,483,205.51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,233,495.50	27,233,495.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,468,418.00)	(22,420,967.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	87,188,253.00	87,188,253.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(38,278,397.97)	(47,415,973.65)
39300	Биет бус хөрөнгө	1,714,791.57	1,402,291.53
39301	Программ хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(755,208.43)	(1,067,708.47)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,220,000.00	1,220,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	417,576,827.05	483,163,797.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	594,000.00	4,002,280.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	594,000.00	4,002,280.00
41300	Өглөг	594,000.00	4,002,280.00
41360	Бусад өглөг	594,000.00	4,002,280.00

41361	Байгууллагад төлөх өглөг	594,000.00	4,002,280.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	416,982,827.05	479,161,517.67
51	Засгийн газрын хувь оролцоо	416,982,827.05	479,161,517.67
51100	Засгийн газрын оруулсан капитал	99,492,449.14	99,492,449.14
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	99,492,449.14	99,492,449.14
51200	Хуримтлагдсан үр дүн	311,771,804.32	373,950,494.94
51210	Өмнөх үеийн үр дүн	(105,211,022.73)	311,771,804.32
51220	Тайлант үеийн үр дүн	416,982,827.05	62,178,690.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,718,573.59	5,718,573.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	417,576,827.05	483,163,797.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	865,077,106.31	626,567,424.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	444,370,389.31	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	444,370,389.31	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	423,343,982.31	0.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,026,407.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,706,717.00	626,567,424.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	342,768,300.00	555,101,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	342,768,300.00	555,101,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,903,417.00	71,466,224.96
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,903,417.00	71,466,224.96
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	448,094,279.26	564,388,734.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,094,279.26	564,388,734.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	448,094,279.26	556,730,334.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,265,154.82	341,135,932.05
210101	Үндсэн цалин	208,577,074.97	262,665,566.92
210102	Нэмэгдэл	51,194,493.85	66,682,317.13
210104	Урамшуулал	4,493,586.00	11,788,048.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,055,934.82	41,153,579.71

210201	Тэтгэврийн даатгал	21,629,857.60	28,487,505.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,464,937.05	3,384,647.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,953,009.84	2,663,718.01
210204	Ажилгүйдлийн даатгал	444,588.75	581,485.15
210205	Эрүүл мэндийн даатгал	4,563,541.58	6,036,223.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,871,417.00	71,466,224.96
210301	Гэрэл, цахилгаан	2,433,217.00	6,348,130.78
210302	Түлш, халаалт	50,292,200.00	62,862,094.18
210303	Цэвэр, бохир ус	4,146,000.00	2,256,000.00
2105	Нормативт зардал	50,519,479.00	57,019,811.00
210502	Хоол, хүнс	50,519,479.00	57,019,811.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	353,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	353,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,790,293.62	45,601,286.62
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,658,547.00	17,287,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,247,290.00	1,178,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,884,456.62	27,135,946.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	7,658,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	7,658,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	7,658,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	416,982,827.05	62,178,690.62
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	416,982,827.05	62,178,690.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН <i>/төгрөгөөр/</i>
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	420,706,717.00	626,567,424.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,706,717.00	626,567,424.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	342,768,300.00	555,101,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	342,768,300.00	555,101,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,903,417.00	71,466,224.96
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,903,417.00	71,466,224.96
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	414,146,996.64	539,763,276.72

21	УРСГАЛ ЗАРДАЛ	414,146,996.64	539,763,276.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	414,146,996.64	532,104,876.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	264,265,154.82	342,664,614.91
210101	Үндсэн цалин	208,577,075.15	241,191,969.00
210102	Нэмэгдэл	51,194,494.31	89,908,658.91
210104	Урамшуулал	4,493,585.36	11,563,987.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,055,934.82	39,624,896.85
210201	Тэтгэврийн даатгал	21,629,857.60	27,391,951.74
210202	Тэтгэмжийн даатгал	2,464,937.05	3,183,303.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,953,009.84	2,533,583.17
210204	Ажилгүйдлийн даатгал	444,588.75	581,453.46
210205	Эрүүл мэндийн даатгал	4,563,541.58	5,934,604.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,871,417.00	71,466,224.96
210301	Гэрэл, цахилгаан	2,433,217.00	6,348,130.78
210302	Түлш, халаалт	50,292,200.00	62,862,094.18
210303	Цэвэр, бохир ус	4,146,000.00	2,256,000.00
2105	Нормативт зардал	51,480,600.00	55,173,300.00
210502	Хоол, хүнс	51,480,600.00	55,173,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	785,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	785,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,881,890.00	22,390,340.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,634,490.00	20,033,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,247,400.00	2,356,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	7,658,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	7,658,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	7,658,400.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,559,720.36	86,804,148.24
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	6,559,720.36	86,804,148.24
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,559,720.36
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,559,720.36	93,363,868.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	416,982,827.05	416,982,827.05
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	311,771,804.32	416,982,827.05
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	311,771,804.32	416,982,827.05
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	311,771,804.32	416,982,827.05
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	62,178,690.62	62,178,690.62
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	373,950,494.94	479,161,517.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	633,127,024.96	539,763,176.72	93,363,848.24	85.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	633,127,024.96	539,763,176.72	468,297,051.76	85.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	561,660,900.00	532,104,776.72	460,638,651.76	94.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,934,100.00	342,664,614.91	342,664,614.91	82.0
210101	Үндсэн цалин	276,433,500.00	241,191,969.00	241,191,969.00	87.3
210102	Нэмэгдэл	127,440,700.00	89,908,658.91	89,908,658.91	70.5
210104	Урамшуулал	14,059,900.00	11,563,987.00	11,563,987.00	82.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,050,500.00	39,624,896.85	39,624,896.85	77.6
210201	Тэтгэврийн даатгал	34,714,200.00	27,391,951.74	27,391,951.74	78.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,084,200.00	3,183,303.87	3,183,303.87	77.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,267,400.00	2,533,583.17	2,533,583.17	77.5

210204	Ажилгүйдлийн даатгал	816,900.00	581,453.46	581,453.46	71.2
210205	Эрүүл мэндийн даатгал	8,167,800.00	5,934,604.61	5,934,604.61	72.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,466,124.96	71,466,124.96	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	6,348,030.78	6,348,030.78	0.00	100.0
210302	Түлш, халаалт	62,862,094.18	62,862,094.18	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,256,000.00	2,256,000.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	61,806,300.00	55,173,300.00	55,173,300.00	89.3
210502	Хоол, хүнс	61,806,300.00	55,173,300.00	55,173,300.00	89.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	785,500.00	785,500.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	785,500.00	785,500.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,426,100.00	22,390,340.00	35,760.00	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,069,700.00	20,033,940.00	35,760.00	99.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,356,400.00	2,356,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,658,400.00	7,658,400.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,658,400.00	7,658,400.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,658,400.00	7,658,400.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	633,127,024.96	626,567,324.96	6,559,700.00	99.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	555,101,200.00	555,101,200.00	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	555,101,200.00	555,101,200.00	0.00	100.0
	Орон нутгийн төсөв	71,466,124.96	71,466,124.96	0.00	
	Дээд шатны төсөв	35,000.00			
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,524,700.00	0.00	6,524,700.00	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,524,700.00	0.00	0.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	6,524,720.36	0.00	

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	93,328,868.60	0.00	
---	---	------	---------------	------	--

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Сургууль цэцэрлэгийн залгамж холбоог сайжруулах, багш болон хүүхдийн тасралтгүй хөгжлийг дэмжих” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны зорилтуудаа дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдлага болон багш ажилчдын үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилтийн талаар багш ажилчид сар бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж цаг ашиглалт, бүтээлч байдал, албан болон хувийн соёлыг чанд сахих, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, шинэлэг зүйл санаачлан ажиллах,
- Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд СӨБ-ын байгууллагын хүүхдүүдийн зохион байгуулагддаг тэмцээн уралдаанд идэвхтэй оролцуулж ажиллах,
- Цэцэрлэгийн багш ажилчдын олон нийтийн оролцооны ажлын талаар авьяас чадварыг хөгжүүлэх, цагийг зөв боловсон өнгөрүүлэх, багаар ажиллах зорилгоор бүсийн спортын наадамд амжилттай оролцох,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, “2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл

ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жавхланта сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,587.0 мянган төгрөгөөр буюу 13.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,559.70	93,363.90	86,804.20
Авлага	-	-	-
Бараа материал	15,557.60	21,476.30	5,918.70
Үндсэн хөрөнгө	395,459.50	368,323.60	(27,135.90)
Нийт хөрөнгө	417,576.80	483,163.80	65,587.00
Өр төлбөр	594.00	4,002.30	3,408.30
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	416,982.80	479,161.50	62,178.70
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	417,576.80	483,163.80	65,587.00

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 93,363.9 мянган төгрөг болж 86,804.2 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9¹-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 21,476.3 мянган төгрөг болж 5,918.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 77,134.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, 71,216.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,

¹ Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 368,323.6 мянган төгрөг болж буурсан нь тайлант онд 27,135.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,
- Өр төлбөр дансны үлдэгдэл 4,002.3 мянган төгрөг болж 3,408.3 мянган төгрөгөөр өссөн нь хоолны материалын өр төлбөр үүсгэснээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 394,711.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 71,478.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **466,190.1** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 9,803.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 10,043.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,948.5 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг **462,001.7** мянган төгрөгөөр баталсан байна.

2023 онд төсвийн зохицуулалтаар цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 148,802.2 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 6,050.1 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 7,658.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 8,627.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тогтмол зардлыг 12.6 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг **633,127.0** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 561,660.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 71,466.2 мянган төгрөг нийт **633,127.0** мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **539,763.2** мянган төгрөг буюу 85.3 хувьтай байгаа нь цалин хөлс, НДШ-ийн зардлыг 86,695.8 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 6,633.0 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 35.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
						зөрүү	Хувь

1	71801- Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,178.20	1,178.20	-	100.0
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	55,616.30	48,983.30	(6,633.00)	88.0
		3	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,747.60	3,747.60	-	100.0
		4	81823- Боловсролын багшийн сургалт	1,178.20	1,178.20	-	100.0
		5	81832-Нүүдлийн бүлэгт хамруулах	24,856.00	24,856.00	-	100.0
		6	81834- Боловсролын стандарт сургалт	314,538.90	235,884.60	(78,654.30)	75.0
		7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	160,510.60	152,469.10	(8,041.50)	95.0
		8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	71,466.20	71,466.20	0.00	100.0
		9	Бусад зардал	35.00	0.00	(35.00)	-
		Нийт		633,127.00	539,763.20	(93,363.80)	85.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ хүүхдийн хоолны зардал 55,616.3 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосонд хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Б.Ундаръяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 452,406.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,524.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 27 мэдээллийг дутуу мэдээлсэн байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээллийг 24 удаа,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг 3 удаагийн мэдээллийг дутуу мэдээлсэн.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Баянжаргал хайрхан” ХХК, Г.Баярсайхан нартай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг

баримтална.”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмж өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй 3,717.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчилд албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3,717.9	1	3,717.9	100.0
Нийт дүн	1	3,717.9	1	3,717.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд **“Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан”** гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Өмнөх онд нярав А.Энхсанаагийн ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал уг албан бигийн дагуу нэг сарын үндсэн цалингийн буюу 868.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт **1,915.4** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланг 1,915.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Аудитаар нийт **4,002.3** мянган төгрөгийн зөрчил илэрч албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас хүнсний материалын 4,002.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланг зөрүүтэй тайлагнасан.	1	1,915.4			1	1,915.4						
Дүн	1	1,915.4			1	1,915.4						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн.	1	4,002.3			1	4,002.3						
Дүн	1	4,002.3			1	4,002.3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны 27 мэдээллийг дутуу мэдээлсэн.	1	-						1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Худалдан авах ажиллагаатай холбоотой.	1	-						1	-
Дүн	1	-	-	-	-	-	-	1	-
Нийт дүн	2	-	-	-	-	-	-	2	-